



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар *А/сч*


Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын V наадмын ширээний шагайн шигшээ тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын V наадмын ширээний шагайн шигшээ тэмцээнийг 2016 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.552.000 /хоёр сая таван зуун тавин хоёр мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны нэмэлт дансны зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнийг урьдчилан бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500127

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2016 оны ... дүгээр сарын
... ны өдөр ... дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын V наадмын
наадмын ширээний шагайн шигшээ
тэмцээний төсөв

| № | Зардлын нэр | Нийт дүн |
|----|---|---------------|
| 1. | Тамирчдын шагнал: 1-р байр 16 хүн x 40.000 ₮ = 640.000 2-р байр 16 хүн x 32.000 ₮ = 512.000 3-р байр 16 хүн x 25.000 ₮ = 400.000 | 1.552.000 төг |
| 2. | Багийн шагнал: 1-р байр 1 x 400.000 ₮ = 400.000 2-р байр 1 x 350.000 ₮ = 350.000 3-р байр 1 x 300.000 ₮ = 300.000 | 1.000.000 төг |
| | Дүн | 2.552.000 төг |

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг